



*Эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр дүнд хийсэн аудитын тайлан*



## Эрчим хүчний байгууллагуудын зарим чиг үүрэгт давхардал байна

# АГУУЛГА

<b>Тайлан бэлтгэсэн:</b>	Товчилсон үгийн тайлбар	2
<b>Гүйцэтгэлийн аудитын газрын дарга</b> С.Төмөрхүү	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<b>Хөрөнгө оруулалтын албаны менежер</b> Г.Гүнжидмаа	<b>Бүлэг 1. Эрчим хүчний үнэ, тарифт олон удаа өөрчлөлт оруулжээ</b>	4
<b>Ахлах аудитор</b> С.Сэрчхорол Д.Цэрэндорж	<ul style="list-style-type: none"><li>• Ерөнхий мэдээлэл</li></ul>	4
<b>Аудитор</b> Ж.Оюунтуяа Э.Уянга	<ul style="list-style-type: none"><li>• Эрчим хүчний салбарын талаарх эрх зүйн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна</li></ul>	4
ҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид	<ul style="list-style-type: none"><li>• Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд эрх үүргийн давхардал байна</li></ul>	6
2015 оны 1 дүгээр сар	<ul style="list-style-type: none"><li>• “Нэг худалдан авагч”-ийнхуримтлагдсан алдагдал 25.9 тэрбум төгрөгт хүрч, эх үүсвэргүй өр 27.7 тэрбум төгрөг болжээ</li></ul>	8
<b>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</b>	<ul style="list-style-type: none"><li>• Эрчим хүчний үнэ, тарифыг 3 удаа өөрчилжээ</li></ul>	10
<a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	<b>Бүлэг 2. Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-уудын өглөг өсчээ</b>	12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 262451, 261675 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу	<ul style="list-style-type: none"><li>• Төрийн өмчит ААНБ-ын авлага өмнөх оноос 9.0 тэрбум төгрөгөөр буурч, өглөг 137.2 тэрбум төгрөгөөр өсчээ</li></ul>	15
<b>ХАЯГ:</b> Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Улаанбаатар-15160 Монгол Улс	<b>Бүлэг 3. Төрийн өмчит ААНБ-уудад хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын үр өгөөж хангалтгүй байна</b>	16
	<ul style="list-style-type: none"><li>• Төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан зөрчил гарсан байна</li></ul>	18
	<ul style="list-style-type: none"><li>• Үйлдвэрлэлийн дотоод хяналт хэвийн явагдаж байна</li></ul>	19
	<b>Дүгнэлт</b>	21
	<b>Холбогдох байгууллагын санал</b>	22
	<b>ҮАГ-аас өгөх тайлбар</b>	24
	<b>Зөвлөмж</b>	25
	<b>Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал</b>	26
	<b>Хавсралт №1</b>	28
	<b>Хавсралт №2</b>	29
	<b>Хавсралт №3</b>	31
	<b>Хавсралт №4</b>	32
	<b>Хавсралт №5</b>	33

## Товчилсон үгийн тайлбар

<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж, байгууллага
<b>ББЭХС</b>	Баруун бүсийн эрчим хүчний систем
<b>БЗА</b>	Барилга захиалагчийн алба
<b>БЗӨБТС</b>	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
<b>ДБЭХС</b>	Дорнод бүсийн эрчим хүчний систем
<b>ДДЦС</b>	Дарханы дулааны цахилгаан станц
<b>ДЦС</b>	Дулааны цахилгаан станц
<b>ДС</b>	Дулааны сүлжээ
<b>ДҮТ</b>	Диспетчерийн үндэсний төв
<b>ӨБЭХС</b>	Өмнөд бүсийн эрчим хүчний систем
<b>СЦС</b>	Салхин цахилгаан станц
<b>СЭХҮТ</b>	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ТЭЗҮ</b>	Техник, эдийн засгийн үндэслэл
<b>ТӨААТҮГ</b>	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
<b>ТБОНӨТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ТӨХ</b>	Төрийн өмчийн хороо
<b>ТӨҮҮГ</b>	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар
<b>УБДС</b>	Улаанбаатар дулааны сүлжээ
<b>УЦС</b>	Усан цахилгаан станц
<b>УБЦТС</b>	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ЦС</b>	Цахилгаан станц
<b>ЦДАШ</b>	Цахилгаан дамжуулах агаарын шугам
<b>ЦДҮС</b>	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа
<b>ЭДЦС</b>	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц
<b>ЭХС</b>	Эрчим хүчний систем
<b>ЭХЗГ</b>	Эрчим хүчний зохицуулах газар
<b>ЭХЗХ</b>	Эрчим хүчний зохицуулах хороо
<b>ЭХС</b>	Эрчим хүчний сайд
<b>ЭХХТ</b>	Эрчим хүчний хөгжлийн төв
<b>ЭХЭЗХ</b>	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

### 1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### 2. Аудитын зорилт

Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын үйл ажиллагаа, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд,

- Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын үйл ажиллагааны хэрэгжилт;
- Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр, зарцуулалт;
- Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын худалдан авалт, гүйцэтгэл ямар түвшинд хийгдсэн талаар шалгалаа.

### 3. Хамарсан хүрээ

Аудитад Эрчим хүчний салбарын 25 төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага хамрагдав.

### 4. Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлагын дагуу аудитын тайлангийн дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгаанд тулгуурлан дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд,

- Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын 2013 он, 2014 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагнал, бусад холбогдох судалгаа материалыг гаргуулан авч нэгтгэн дүгнэв.
- Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-дад 2013-2014 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан эсэхийг шалгав.
- Эрчим хүчний яам болон холбогдох агентлаг, төвөөс хөрөнгө оруулалтын талаар шаардлагатай судалгаа, материалыг гаргуулан, ярилцлага хийж, тодруулга авлаа.

## **Бүлэг 1. Эрчим хүчний үнэ тарифт олон удаа өөрчлөлт оруулжээ**

### **Ерөнхий мэдээлэл**

1.1 Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-д дулааны цахилгаан станц 6, дулааны станц 3, усан цахилгаан станц 2, цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ 1, цахилгаан түгээх сүлжээ 4, эрчим хүчний систем 3, дулааны сүлжээ 2, Эрчим хүчний хөгжлийн төв, Диспетчерийн үндэсний төв, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Эрчим хүчний үндэсний хүрээлэн, Эрчим хүчний зохицуулах хороо хамрагдаж байна.

1.2 Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2013 онд 5132.2 сая.кВтц болж, өмнөх оноос 5.7 хувиар өссөн ба нийт цахилгааны 97.7 хувийг ДЦС, 0.9 хувийг УЦС, 0.8 хувийг нар салхины эх үүсвэрээр, 0.1 хувийг дизель станцаар үйлдвэрлэжээ.

1.3 Улсын хэмжээнд 2013 оны байдлаар 508877 цахилгааны, 225114 дулааны эрчим хүчний хэрэглэгч байна.

### **Эрчим хүчний салбарын талаарх эрх зүйн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна**

1.4 Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилт”-од суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт 2007-2015 онд “Эрчим хүчний нэгдсэн систем”-ийг байгуулж эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, хөгжлийн нэн таатай орчинг бий болгох, эрчим хүч экспортолдог чадамжтай болох зорилтыг хэрэгжүүлэхээр заажээ.

1.5 УИХ, Засгийн газраас эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- ✚ Төрийн өмчит компаниудын урт хугацаат зээлийн дүнг анх авах үеийн ханшаар тооцон зээлийн гэрээг өөрчилснөөр зээлийн дүнг 2012 онд 80.4 тэрбум төгрөгөөр бууруулсан;
- ✚ Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн урт хугацаат зээлийн дүнг 24.7 тэрбум төгрөгөөр бууруулсан;
- ✚ Төвийн бүсийн 5 ДЦС-д 2010 онд 11.9 тэрбум, 2011 онд 12.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс татаасаар олгож, нүүрсний өрийг барагдуулсан;
- ✚ Мөн улсын төсвөөс 2010 онд 35.1 тэрбум, 2011 онд 42.4 тэрбум, 2012 онд 38.0 тэрбум, 2013 онд 32.6 тэрбум төгрөгийг төвийн болон орон нутгийн компаниудад татаасаар олгосон ба 2014 онд 29.3 тэрбум төгрөгийн татаас батлагдсан;
- ✚ 2010-2014 онд эрчим хүчний компаниудын засвар шинэчлэлийн ажилд зориулж нийт 218.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олгожээ.

1.6 Ингэснээр эрчим хүчний цахилгаан дамжуулалт, түгээлтийн нийт алдагдал 2010 онд 17.3, 2011 онд 16.6, 2012 онд 16.3, 2013 онд 15.8 хувь болж буурсан байна.

1.7 Системийн хэмжээгээр 2012 онд дотоод хэрэгцээнд зарцуулсан цахилгаан эрчим хүч өмнөх оноос 0.12 пунктээр, 2013 онд 0.3 пунктээр буурч, 14.6 хувь болгожээ.

1.8 Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2012 онд цахилгаанд 324.1 гр\кВтц байсан бол 2013 онд 326.2 гр\кВтц, дулаанд 178.1 кг\Гкал байсан бол 2013 онд 178.8 кг\Гкал болж, 2010-2013 онд 58.3 сая.кВтц цахилгаан эрчим хүч буюу 4.9 тэрбум, 67.5 мянган тонн нүүрс буюу 1.2 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна.

1.9 Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх зарим зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Тухайлбал,

УИХ-ын тогтоол	Хэрэгжээгүй заалт
"Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол	<b>8 дугаар заалт</b> "эрчим хүчний салбарын компаниудыг 2014 оноос эхлэн Эрчим хүчний тухай хуулийн 26.2.1, 26.2.5-д заасны дагуу зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх".
"Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр шинэчлэн батлах тухай" УИХ-ын 2007 оны 10 дугаар тогтоол	<b>9 дүгээр заалт</b> "Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан түгээх сүлжээг бүрэн шинэчлэж, өвлийн улиралд шөнийн цагаар ахуйн цахилгааны хэрэглээний үнэ, тарифыг "0" төгрөгт шилжүүлэх талаар бодлого боловсруулах".
"Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2011 оны 11 дүгээр тогтоол	Хөтөлбөрийн хэрэгжүүлэх нэгдүгээр үе шат буюу ойрын хугацаа /2007-2012 он/-нд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 14 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй.
"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол	<b>5 дугаар заалт</b> эрчим хүчний шинэ эх үүсвэр 5, 6 дугаар цахилгаан станцыг барих ажлыг 2011 онд эхлүүлэн 2013 онд эхний ээлжийг ашиглалтад оруулж 2014 онд барьж дуусгах
"Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол	<b>4.4-ийн 2.3-т</b> эрчим хүчний 5 дах эх үүсвэрийг барьж ашиглуулах ...Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит компанийн удирдлагад хариуцлага тооцож, ашигтай ажиллахаар өөрчлөн зохион байгуулах Эдийн засгийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний суурь дэд бүтцийг бий болгох зорилгоор ДЦС-5-ыг барих. Дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох улс болох

1.10 Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-уудын зээлийн дүнг бууруулж, нүүрсний өрийг барагдуулан, татаас, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсээр байгаа боловч санхүүгийн чадавхид дорвитой үр дүн харагдахгүй байна.

1.11 Эрчим хүчний тухай хууль, УИХ-аас гаргасан тогтоолд заасан эрчим хүчний салбарын компаниудыг зах зээлийн зарчимд шилжүүлэх, эрчим хүчний найдвартай хангамжийн нэгдсэн системийг байгуулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр барих, эрчим хүч экспортлох зэрэг зорилтууд бүрэн хэрэгжээгүй байна.

**Төрийн байгууллагын үйл ажиллагаанд эрх зүйн дагвардал байна**

1.12 Эрчим хүчний тухай хууль болон бусад эрх зүйн актаар дараах байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг заажээ. Үүнд,

1.13 Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлд: “Эрчим хүчний зохицуулах хороо” эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна гэж заасан бол тус хуулийн 10 дугаар зүйлд “Диспетчерийн үндэсний төв” нь эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байна гэж хуульчилжээ.

**Тусгай зөвшөөрөл олголтын талаар:**

1.14 Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-д Эрчим хүчний зохицуулах хороо-тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгохоор заасны дагуу гүйцэтгэж ирсэн байна.

1.15 ЭХС-ын баталсан журмын дагуу Эрчим хүчний хөгжлийн төв нь зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргаж сайдын тушаалаар тусгай зөвшөөрөл олгодог байна.

**Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засаг, санхүүгийн тооцоо судалгаа хийх, хянан шалгах талаар:**

1.16 **ТӨХ** нь ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэсэн заалтын дагуу эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

1.17 **ЭХЗХ** Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14-16-д эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох, аргачлалыг батлах, тооцоог хянах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх, эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэх журам баталдаг байна.

1.18 **ДҮТ** Арилжаа зохицуулалтын алба байгуулан ажиллах үүргийг тус тус гүйцэтгэж байна.

**Мөнгөн урсгалын зохицуулалтын талаар:**

1.19 **ЭХЗХ** цахилгаан эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулах, хуваарилах, хувь хэмжээг тогтоох аргачлал батлах;

1.20 **ДҮТ**-ийн арилжаа зохицуулалтын алба- Нэгдсэн сүлжээний хэмжээнд зах зээл дээр арилжаалагдсан цахилгаан эрчим хүчний мөнгөн урсгалын нэгдсэн баланс гаргах;

1.21 **ЦДҮС ТӨХК** хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний төлбөрийн төвлөрсөн орлогын дүнгээс мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлын дансуудад шилжүүлэх мөнгөний хувь хэмжээг урьдчилан тооцож иржээ.

**Зураг төсөл боловсруулах үйл ажиллагааны талаар:**

1.22 **ЭХҮХ** эрчим хүчний зураг төсөл боловсруулах, норм нормативын хяналт хийх;

1.23 **ДҮТ** нэгдсэн сүлжээнд шинээр холбогдож буй объектын цахилгаан хангамж, системийн горимын тооцоо болон реле хамгаалалтын автоматикийн тавилын тооцоо, зураг төсөв хийх;

1.24 **ЭХХТ** салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх байршил сонгох, судалгааны ажлын ТЭЗҮ, зураг, төсөл зохиох үйл ажиллагааг тус тус эрхэлж байна.

1.25 Эндээс харахад нэг ижил төрлийн үйл ажиллагааг хэд хэдэн байгууллага гүйцэтгэж байгаа тул эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын бүтэц, зохион байгуулалтыг эргэн харах шаардлага гарч байна.

1.26 ТӨХ-ноос компаниудын санхүүгийн үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, орлого, зарлага, төлөвлөгөөний биелэлт, ХАА-нд жил бүр шалгалт хийж, дүнг ТӨХ-ны хурлаар оруулж, зөрчил дутагдал илэрсэн нөхцөлд хариуцлага тооцож, үүрэг даалгавар өгч ажилладаг байна.

1.27 Харин ЭХЗХ эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-уудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ, тарифыг тогтоож, орлого, зардалд хяналт тавьж, төвийн бүсийн эрчим хүчний төрийн өмчит компаниудын удирдлагуудын хүрээнд мөнгөний урсгалыг улирал тутам тооцож хуваарилдаг байна.

1.28 Үүнээс шалтгаалан ТӨХ төлөвлөгөө батлахдаа ихээхэн цаг хугацаа алддаг байна.

1.29 Ийм учраас эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг төлөвлөх, зардалд хяналт тавих үйл ажиллагааг ТӨХ, ЭХЗХ хамтран хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

1.30 Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3<sup>1</sup>-д заасны дагуу Ерөнхий сайд зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр, орон тооны бус хоёр зохицуулагчийг томилдог бөгөөд 2012 оны 12 дугаар сараас эхлэн орон тооны бус нэг зохицуулагчийг томилолгүйгээр ажиллаж иржээ.

---

<sup>1</sup> Эрчим хүчний тухай хуулийн 8.3-т Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно.



1.31 Энэ нь ЭХЗХ-ны хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн зохицуулагчдын зөвлөлийн хурлаар асуудал шийдвэрлэх (эрчим хүчний үнэ, тариф, зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох, төсөв батлах) үйл ажиллагааны хараат бус байдалд нөлөөлөх нөхцлийг бий болгож байна.

**Нэг худалдан авагчийн хуримтлагдсан алдагдал 25.9 тэрбум төгрөгт хүрч, эх үүсвэргүй өр 27.7 тэрбум төгрөг болжээ**

1.32 Дэд бүтцийн сайдын (хуучнаар) 2002 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төвийн бүсийн цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд мөрдөх төвийн бүсийн нэгдсэн сүлжээний нэг худалдан авагчтай загвар”, “Тус нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулах загвар”-ыг тус тус баталжээ.

1.33 Батлагдсан загварын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааг зохицуулах дүрэм, төлбөрийн мөнгөн урсгалыг зохицуулах хувь хэмжээг тогтоох аргачлалыг баталж, хэрэгжүүлэхийг ЭХЗГ (хуучнаар)-т даалгажээ.

1.34 “Нэг худалдан авагч” төвийн бүсийн 5 ДЦС, 1 цахилгаан станц, Ухаахудгийн ДЦС-аас болон импортоор ОХУ-аас цахилгаан эрчим хүч худалдан авч, 13 цахилгаан түгээх сүлжээ компанид борлуулж, нэг худалдан авагчийн үүргийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК хэрэгжүүлдэг байна.

1.35 Цахилгааны орлогыг “0.0” үлдэгдэлтэй дансууд болон нэгдсэн дансаар дамжуулан урьдчилан тогтоосон хувь хэмжээний дагуу банк үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгчийн дансанд өдөр бүр автоматаар хуваарилдаг ба худалдаж авсан цахилгаан эрчим хүч, түгээх сүлжээнүүдээс төвлөрүүлсэн орлоготой тэнцэх ёстой байна.

1.36 Төвийн бүсийн “Нэг худалдан авагч” нь 2010 онд 2823.4 сая, 2011 онд 259.4 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2012 онд 1680.8 сая, 2013 онд 5264.2 сая, 2014 оны эхний 9 сарын байдлаар 19001.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байна.

1.37 Дулааны цахилгаан станцууд 2013 онд 4036.0 сая.кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн бол 325.3 сая.кВтц эрчим хүчийг импортоор, 51.6 сая.кВтц цахилгаан эрчим хүчийг Клин Энержи ХХК-ийн Салхит СЦС-аас тус тус худалдан авчээ.

1.38 Худалдан авсан цахилгаан эрчим хүчний 53.6 хувийг УБЦТС компанид, 0.5 хувийг экспортод гаргаж, үлдсэн 45.9 хувийг бусад түгээх сүлжээ компани болон аж ахуйн нэгж байгууллагуудад борлуулжээ.

1.39 2013 онд 263.3 тэрбум төгрөгийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, дамжуулалтын зардалд 20.5 тэрбум төгрөг гарч, 278.5 тэрбум төгрөгөөр борлуулж, үйлдвэрлэлээс 5.2 тэрбумын төгрөгийн алдагдал хүлээжээ.

1.40 “Нэг худалдан авагч”-ийн алдагдал өсөн нэмэгдэж байгаа нь дараах нөхцөл байдлаас шалтгаалжээ. Тухайлбал,

- Клин Энержи ХХК-ийн “Салхит” СЦС-аас 2013 оны гүйцэтгэлээр 51.5 сая.кВтц цахилгаан эрчим хүчийг 8.1 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр худалдаж авсан. “Сэргээгдэх эрчим хүчний тухай” хуулийн дагуу тус станцаас 1 кВтц ЦЭХ-ийг 9.5 ам.цент/кВтц (157.43 төг/кВтц)-аар худалдан авсан нь төвийн бүсийн 5 ДЦС-ын дундаж үнэ (60 төг/кВтц)-ээс 2.6 дахин өндөр байгаа;
- ОХУ-аас импортоор авсан цахилгаан эрчим хүчний үнэ гэрээний дагуу хагас жил тутамд нэмэгдэж байгаа бөгөөд 2013 оны 7 дугаар сарын 1-нээс чадлын тариф 12.1 хувь, мВт, энергийн тариф 7.03 хувиар нэмэгдэж, валютын ханш (ам.долларын ханш оны эхэнд 1392.3 төгрөг байсан бол жилийн эцэст 1726.32 төгрөг болж 24.0 хувиар) өссөнөөс шалтгаалан импортоор худалдаж авсан цахилгаан эрчим хүчний төлбөр 2013 онд 10394.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.


1.41 Үүнээс үзэхэд, импортоор авсан цахилгаан эрчим хүчний тариф 125.2 төгрөг кВтц, Салхит СЦС-ын тариф 157.4 төгрөг кВтц байхад, ДЦС-4, ДЦС-3, ДЦС-2-ын тарифт өртөг 39.8-94.9 төгрөг кВтц байгаа бөгөөд үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг түгээж борлуулсан дундаж тариф 65.2 төгрөг кВтц байна.

1.42 “Нэг худалдан авагч”-ийн “0.0” үлдэгдэлтэй орлогын дансанд 2013 онд 338.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрснөөс 275.5 тэрбум төгрөгийг цахилгаан станцуудад хуваарилж, үлдсэн 61.4 тэрбум төгрөгийг түгээх сүлжээ компаниудад, 1.9 тэрбум төгрөгийг ДҮТ-д хуваарилсан байна.

1.43 “Нэг худалдан авагч”-ийн алдагдлаас шалтгаалж “0.0” үлдэгдэлтэй дансны өглөг 2013 оны эхэнд 12.1 тэрбум төгрөг байсан бол, тайлант онд 8.7 тэрбум төгрөг нэмэгдэж, оны эцэст 20.8 тэрбум төгрөг болж өсчээ.

1.44 Төвийн бүсийн “Нэг худалдан авагч”-ийн 2010-2014 оны эхний 9 сарын цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаас авах авлага болон дулааны цахилгаан станцуудад өгөх өглөгийг графикаар харуулав.

Нэг худалдан авагчийн “0.0” үлдэгдэлтэй дансны өр, авлага, тэрбум.төг (Өссөн дүнгээр)



1.45 ОХУ-аас нийлүүлсэн импортын болон Салхн СЦС-ын төлбөрөөс хамааран тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд 2014 оны эхний 9 сарын байдлаар эх үүсвэргүй 28.7 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

1.46 “Нэг худалдан авагч”-ийн тайлангаар хуримтлагдсан алдагдал 25.9 тэрбум, НӨАТ-ын авлага 2.8 тэрбум төгрөгөөс тус тус бүрдэж байна.

**Эрчим хүчний үнэ, тарифыг 3 удаа өөрчилжээ**

1.47 ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн (хуучнаар) “Тариф батлах тухай” 2007 оны 50 дугаар тогтоолоор Салхит СЦС-аас цахилгаан үйлдвэрлэн нийлүүлэх тарифыг 0.095 ам.доллар кВт.ц-аар тогтоож, цахилгаан үйлдвэрлэж эхэлсэн өдрөөс эхлэн 20 жилийн хугацаанд мөрдөхөөр заажээ.

1.48 Энэ нь төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1<sup>2</sup> дэх заалттай зөрчилдөж байна.

1.49 Импортоор болон СЦС-аас авч байгаа цахилгаан эрчим хүчний төлбөрийг ам.доллараар тооцож байгаагийн зэрэгцээ валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан дотоодод үйлдвэрлэж байгаа цахилгаан эрчим хүчний дундаж үнээс 50 хувиар илүү үнээр худалдан авч байна.

1.50 УИХ-ын “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 72 дугаар тогтоолд “2014 оноос эхлэн Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1, 26.2.5-д заасны дагуу зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх” гэж заасан байна.

1.51 Гэвч ЭХЗХ-ноос тариф тогтоохдоо үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах (26.2.1), тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх (26.2.5) гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.52 ЭХЗХ-ноос үнэ тарифыг батлахдаа өмнөх онуудын гүйцэтгэлийг бенчмарк үзүүлэлт болгон авч хянадаг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тухайн жилийн хувьд хангах боломжгүй зардал тарифт суулгадаг, хөрөнгө мөнгөний хүрэлцээгүйгээс зардлуудыг байнга хасч танаж байгаа нь дараа дараагийн тариф батлуулахад сөрөг нөлөө үзүүлж иржээ.

1.53 Мөн зайлшгүй тогтмол, тогтоогдсон тарифын дагуу гарч байдаг түлш, төмөр замын тээврийн зардал, татвар, хураамж, урт хугацаат зээл, зээлийн хүүгийн зардлуудыг хугацаа алдаж, үнэ тарифт суулгаснаар зарим компанид алдагдал үүсэх нөхцөл бий болж байна. Ганц жишээ авч үзвэл,

✚ ДЦС-4 ТӨХК-д 2011 оны 5 дугаар сарын 01-нд шинэчлэн батлагдсан тарифаар урт хугацаат зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 2 жилийн дараа 2013 оны 8 дугаар сарын 20-нд баталсан тарифаар зөвхөн урт хугацаат зээлийн хүүг нь суулгаж, үндсэн төлбөр төлөх эх үүсвэрийг дутуу шийджээ.

1.54 Мөн эрчим хүчний үнэ тарифыг нэмэхдээ хамгийн том үйлдвэрлэгч болох ДЦС-4 ТӨХК-ийн тарифыг хамгийн багаар нэмж иржээ. Тухайлбал,

<sup>2</sup> Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1 дэх заалт: Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монгол банкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно

- ✚ 2013 оны 8 дугаар сарын 20-ноос мөрдөгдсөн тарифт тус компанийн тариф 11.9 хувиар өссөн байхад бусад үйлдвэрлэгчийн тариф 18.61-34.13 хувиар өссөн;
- ✚ 2014 оны 7 дугаар сарын 21-нээс мөрдөж байгаа тарифаар 3.74 хувиар өссөн байхад Дархан ДЦС-ийн тариф 23.3 хувиар нэмэгдсэн;
- ✚ Үйлдвэрлэлд ашиглаж байгаа гүний ус нь 2011 оноос эхлэн төлбөртэй болсон учраас 2012 онд 224.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан боловч, тарифт 2013 оны 8 дугаар сарын 20-нд суулгаж өгсөн байна.


1.56 Эрчим хүчний үнэ тариф тогтоохдоо үйлдвэрлэгчээс шалтгаалахгүйгээр өөрчлөгдөж байгаа төлбөр хураамж, зардлын өсөлтүүдийг тооцдоггүйгээс бодит зардал өсч, өр төлбөр нэмэгдэж, алдагдал үүсэх нэг нөхцөл болж байна.Тухайлбал,

**ДЦС-уудад**

- ✚ Үл хөдлөх хөрөнгийн татварын бүсчлэл өөрчлөгдсөнөөс шалтгаалан татварын хэмжээ өөрчлөгдсөн байхад 2014 оны 7 дугаар сарын 21-нээс тарифт суулгаж өгсөн;
- ✚ Энэ оны хувьд төмөр замын нүүрс тээвэрлэх тариф 2014 оны нэгдүгээр сарын 28-ны өдрөөс 10 хувь өссөн байхад, үнэ тарифт 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн тусгасан байх жишээтэй.

1.57 ЭХЗХ эрчим хүчний үнэ, тарифыг 2014 оны 7 дугаар сарын 21, 8 дугаар сарын 5, 11 дүгээр сарын 19-нд 3 удаа өөрчлөн тогтоосон нь 2011 оны 5 дугаар сарын 1-нд мөрдөж эхэлсэн үнээс 1.19-1.52 хувиар өссөн байна.

1.58 Цахилгаан эрчим хүчний сүүлийн 4 жилийн үнэ тарифыг графикаар харуулбал,



1.59 Айл өрхийн сарын 150 кВтц-аас илүү хэрэглэсэн цахилгааны үнийг 1.21 хувиар, 2 тарифт тоолуурын өдрийн хэрэглээг 1.06 хувиар тус тус нэмэгдүүлж, оройн хэрэглээг 0.77 хувиар бууруулжээ. (Хавсралт №1)

1.60 Төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах эрчим хүчний үнэ, тарифыг 2013 онд нэг, 2014 онд 3 удаа өөрчилсөн нь 2011 оны 5 дугаар сарын 01-нд мөрдөж эхэлсэн үнээс 1.13-1.15 хувиар, Дархан-Уул аймгийн Дархан сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф 1.15-1.64, Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф 1.15-1.34 хувиар тус тус өссөн байна. (Хавсралт №2)

1.61 Ингэж эрчим хүчний үнэ тарифыг ойр ойрхон олон удаа өөрчилж байгаа нь “Нэг худалдан авагч”-ийн тайлангаар гарсан алдагдлыг бууруулах, ДЦС-уудын авлагыг барагдуулахад чиглэгдэж байгаа боловч нөгөө талаар үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагааны зардал болон айл өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

**Бүлэг 2. Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-уудын өглөг өсчээ**

2.1 **ЭХЗХ** эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж улсын бүртгэлд бүртгэгджээ.

2.2 Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.19-д заасны дагуу тус хорооны зардал, хөрөнгө оруулалтын төсөв, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ЭХЗХ-ны тогтоолоор баталдаг болжээ.

2.3 ЭХЗХ-ны 43 дугаар тогтоолоор 2013 оны төсвийг 1381.9 сая, мөн оны 123 дугаар тогтоолоор 1222.2 сая төгрөгөөр өсгөж, нийт 2605.0 сая төгрөг болгожээ.

2.4 Дутагдсан эх үүсвэрийг бий болгохын тулд 2013 оны 92 дугаар тогтоолоор эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөлтэй 11 ААНБ-аас 230.2 сая, 12 дугаар сарын 05-ны өдрийн 182 дугаар тогтоолоор 54 ААНБ-аас 345.1 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг авахаар баталсан байна.

2.5 2014 онд 2160.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, эхний 9 сарын байдлаар 1286.5 сая төгрөг зарцуулсан байна.

2.6 Засгийн газрын тогтоолоор тус байгууллагын төсвийг 2008-2011 онд 539.0-856.3 сая төгрөгөөр баталж байсан бол 2012 онд хорооны тогтоолоор төсвийг 1249.8 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 393.5 сая төгрөг буюу 45.9 хувиар өссөн байна

2.7 Эрчим хүчний тухай хуулиар ЭХЗХ-нд төсвөө батлах, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох эрх олгосон нь хорооны төсөв болон зардлын өсөлтийг хязгаарлах боломжгүй болгосон байна.

2.8 **ЭХХТ** Засгийн газрын 2012 оны 51 дүгээр тогтоолоор ЭХЯ-ны харьяанд Эрчим хүчний хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах шийдвэр гаргасан байна.

2.9 ЭХХТ-ийн 54.2 хувь буюу 1892.5 сая төгрөгийн орлогыг захиалагчийн хяналт, 23.0 хувь буюу 801.2 сая төгрөгийг тусгай зөвшөөрөл олгосон, 11.7 хувь буюу 409.1 сая төгрөгийг хөгжлийн судалгааны орлого, 5.4 хувь буюу 187.3 сая төгрөгийг сургалт, буудлын орлого, үлдсэн 5.7 хувь буюу 198.6 сая төгрөгийг хими, металлын лабораторийн болон бусад орлого эзэлж байна.

2.10 Тус төв нь 2013 онд 3262.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 3242.2 сая төгрөгийн зардал зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3488.8 сая төгрөгийн орлого орж, 2740.5 сая төгрөгийн зардал гарчээ.

2.11 **СЭХҮТ** ТӨААТҮГ-ыг Засгийн газрын 2009 оны 58, 146 дугаар тогтоолоор байгуулж, нарны зайн үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр судалгаа, туршилт хийх, зураг төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж

үйлдвэрлэж, гадаад, дотоодын зах зээлд борлуулах, хуулиар хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагааг эрхлэхээр заажээ.

2.12 БХБЯ-наас “барилга угсралт”, “зураг төсөл”-ийн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авчээ.

2.13 ТӨХ-ноос тус төвийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталдаг бөгөөд 2013-2014 онд нийт 407.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 10 ажил гүйцэтгэж, 425.3 сая төгрөгийн 35 ажил гүйцэтгүүлсэн боловч үр дүнг тооцож тайлагнаагүй байна.

2.14 2013 онд тус төв 70.1 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 2014 оны эхний хагас жилийн байдлаар 211.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

2.15 СЭХҮТ-д өөрийн эзэмшлийн сэргээгдэх эрчим хүчний станц байхгүй, сэргээгдэх эрчим хүчний чиглэлд бодлогын шинжтэй ажил хийдэггүй, үндсэн чиг үүргээс туршилт, судалгаа хийх ажлуудыг голчлон хийж байгаагаас үзвэл цаашид сэргээгдэх эрчим хүчний салбарт бодитой хувь нэмэр оруулахуйц байдлаар зохион байгуулах шаардлагатай байна.

2.16 **Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ нь** 2013 онд 682.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оноос 85.5 тэрбум төгрөгөөр өсч, борлуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал 660.3 тэрбум болж, өмнөх оноос 73.7 тэрбум төгрөгөөр өсчээ. (Хавсралт №3-4)

2.17 2013 онд тайлант үеийн алдагдал 29.7 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 4.1 тэрбум төгрөгөөр буурчээ.

2.18 Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-аас 2013 онд дараах байгууллагууд ашигтай ажиллажээ. Үүнд:

✚ СЭХҮТ 70.1 сая, УБЦТС 10.9 сая, Эрчим корпораци 45.7 сая, ӨБЦТС 414.0 сая, ЭХЗХ 631.9 сая, ЭХХТ 631.9 сая, УБДС компани 2513.8 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.19 Эндээс харахад цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэгч компаниудын дийлэнх нь алдагдалтай ажиллаж, харин дээрх байгууллагуудаас зохицуулалтын үйлчилгээний хөлс авдаг, тусгай зөвшөөрөл олгодог, захиалагчийн хяналт, судалгаа туршилт хийдэг аж ахуйн нэгжүүд ашигтай ажилласан байна.

2.20 Аудитад хамрагдсан эрчим хүчний төрийн өмчит 25 ААНБ-уудаас 18 нь алдагдалтай ажилласны 8 нь өмнөх оноос алдагдлаа бууруулжээ.

2.21 Харин тайлант үеийн алдагдлын хэмжээ нь өмнөх оноос өссөн ААНБ-ууд цөөнгүй байна. Үүнд,

✚ Дорнод, Баруун, Алтай-Улиастайн эрчим хүчний системүүд, ЦДҮС, БЗӨБЦТС, Дархан, Налайх, Багануур дулааны станцууд, Дулаан-Шарын гол ТӨХК г.м.

2.22 Эрчим хүчний салбарын төрийн өмчит БНДС, Даланзадгад ДЦС, ДЦС-2, ДЦС-4, ББЭХС, ДҮТ ТӨХК-иуд орлогоо бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.23 Эрдэнэт-Булган цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь орлогын “0.0” үлдэгдэлтэй харилцах данснаас 2013 онд 906.9 сая, 2014 оны эхний хагас жилд 333.9 сая төгрөгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр зарцуулсан зөрчил гаргасан байна.

2.24 Төвийн бүсийн эрчим хүчний системийн ААНБ-уудын үйлдвэрлэлийн зардал жил ирэх тутам өссөөр байна. Үүнд,

(сая төгрөг)

ДЦС-ын нэр	Үйл ажиллагааны зардал		Нэмэгдсэн
	2012 он	2013 он	
ДЦС-2	12085.5	12328.6	243.1
ДЦС-3	68912.2	71302.3	2390.1
ДЦС-4	144365.7	156929.4	12563.7
ДДДС	24511.3	26016.7	1505.4
ЭДЦС	21823.1	23763.9	1940.8
ДҮН	271697.8	290340.9	18643.1

2.25 Эндээс харахад төвийн бүсийн 5 компанийн цахилгаан, дулаан үйлдвэрлэсэн зардал өмнөх оноос 7.0 хувиар өссөн байна.

Эх сурвалж: ЭХЗХ-ны 2013 оны үйл ажиллагааны тайлан

2.26 Үйлдвэрлэлийн зардлын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл:

- ✚ Түлшний зардал 5.7 тэрбум;
- ✚ Цалингийн зардал 12.6 тэрбум;
- ✚ Бусад тогтмол зардал 3.4 тэрбум;
- ✚ Ажиллагсдын нийгмийн зардал 1.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2.27 Мөн тус салбарын орон нутаг дахь төрийн өмчит ААНБ-уудын зардлыг бодитой төлөвлөөгүйгээс батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал,

- ✚ ДБЭХС 1954.8 сая төгрөгөөр төсвөө хэтрүүлсний дотор шатахууны зардал 300.3 сая, ажилчдын нийгмийн зардал 184.0 сая, урсгал зардал, сэлбэг материал 169.2 сая, үндсэн ба нэмэгдэл цалин 70.3 сая, бусад зардал 232.2 сая, үйл ажиллагааны бус зардал 1187.0 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн;
- ✚ ББЭХС 604.2 сая төгрөгөөр төсвөө хэтрүүлсний 591.9 сая төгрөг нь эрчим хүчний төлбөртэй, ажилчдын нийгмийн зардал 73.5 сая, бусад зардал 101.2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн нь ОХУ-аас импортоор худалдан авах цахилгаан эрчим хүчний нэгжийн үнэ 2013 оны 7 дугаар сарын 01-нээс эхлэн өссөн нь нөлөөлсөн;
- ✚ Алтай-Улиастай ЭХС нь батлагдсан төсвийг 119.1 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

2.28 Төрийн өмчит ААНБ-уудаас 2013 онд төсөвт тусгагдаагүй зориулалт бусаар хөрөнгө мөнгө зарцуулсан дутагдал илэрлээ. Үүнд,

- ✚ ӨБЦТС компани 2013 онд 3.6 сая, 2014 онд 2.1 сая;
- ✚ Багануурын ДС 2013 онд 30.0 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулжээ.

2.29 Эрчим хүчний зарим салбарт ажиллагсдын тоо 2013 онд өмнөх оноос нэмэгдсэн байна. Тухайлбал,

- ✚ 2013 онд ЦДҮС 90, УБЦТС 49, ДЦС 39, Алтай-Улиастай ЭХС 28, ДДЦС 17, ББЭХС 11 хүнээр өмнөх оноос тус тус өсч, ажиллагсдын дундаж цалин 10-30 хувиар нэмэгджээ.

2.30 Эрчим хүчний салбарын төрийн өмчит 20 ААНБ-уудын ТУЗ-ын даргад 5, гишүүдэд 18, дарга, гишүүнд 3, нийт 26 төрийн албан хаагч давхар ажиллаж байгаа нь

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3-т заасан компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглосон болон 84.3.1<sup>3</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

2.31 Зардал хэмнэж, өртөг бууруулах үүднээс орон тоо бүтцийг оновчтой зохион байгуулж, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

**Төрийн өмчит ААНБ-уудын авлага өмнөх оноос 9.0 тэрбум төгрөгөөр буурч, өглөг 137.2 тэрбум төгрөгөөр өсчээ**


2.32 Эрчим хүчний төрийн өмчит ААНБ-уудын авлага 2013 онд өмнөх оноос 9.0 тэрбум төгрөгөөр буурч, харин богино хугацаат өр 21.4 тэрбум, урт хугацаат өр төлбөр 115.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

2.33 Засгийн газрын 2013 оны “Нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 186 дугаар тогтоолоор 80.0 тэрбум төгрөгийн зээлийг нэг жилийн хугацаатай хөнгөлөлттэй нөхцлөөр олгохоор шийдвэрлэсэн байна.

2.34 ЭХЯ 16 аж ахуйн нэгж байгууллагад арилжааны 6 банкаар дамжуулан 78.7 тэрбум төгрөгийн зээл олгохоор баталсаны 37.7 тэрбум төгрөгийг нүүрсний өр барагдуулах, 36.0 тэрбум төгрөгийг сэлбэг, бараа материал авахад зарцуулж, 12 ААНБ зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, хугацаагаа сунгажээ.

2.35 ДЦС-уудын “Нэг худалдан авагч”-ийн “0.0” үлдэгдэлтэй данснаас авлагаа бүрэн авч чадаагүйгээс банкнаас авсан хүүтэй зээлийг нүүрсний үнэ төлөх, өр төлбөрөө барагдуулахад зарцуулж байна.

2.36 Алтай-Улиастай ЭХС 500.0 сая төгрөгийн зээл авснаас 202.2 сая төгрөгийг нь зориулалт бусаар зарцуулжээ. Үүнд,

 Мөрөн цахилгаан дамжуулах сүлжээний энергийн тооцооны төлбөрт 125.3 сая, дотоод үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 76.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

2.37 ДҮТ дамжуулан зээлдүүлэх зээлийн 150.7 сая, хүүгийн төлбөр 145.9 сая, нийт 296.7 сая, УБЦТС компани Дэлхийн банкны санхүүжилтээр дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн төлбөр 629.8 сая, хүүгийн төлбөр 576.4 сая, нийт 1208.9 сая төгрөгийг тус тус төлөөгүй байлаа.

2.38 Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-уудын урт хугацаат зээлийн өр төлбөр нэмэгдэхэд Засгийн газрын бонд, Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн урт хугацаат зээл тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

<sup>3</sup> Компанийн тухай хуулийн 84.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашидаг;



**Бүлэг 3. Төрийн өмчит ААНБ-уудад хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын үр өгөөж хангалтгүй байна**

3.1 Эрчим хүчний салбарт 2013 онд 288.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 89 төсөл, арга хэмжээнд 117.1 тэрбум, 2014 онд 368.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээнд 82.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

3.2 Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж 2011 онд ашиглалтад оруулах 2, 2013 онд ашиглалтад оруулах 3, 2014 оны эхний 9 сарын байдлаар ашиглалтад оруулах 8 төсөл, арга хэмжээг улсын комисст хүлээлгэн өгөөгүй байна.Тухайлбал,

**2011 онд ашиглалтад оруулах:**

- ✚ УБ хотын “Хаалттай хуваарилах байгууламж 7-гийн хүчин чадал нэмэгдүүлэх, өргөтгөх”;
- ✚ Булган аймгийн Дулааны шугамын өргөтгөл, дэд станцын ажил одоо хүртэл ашиглалтад ороогүй;

**2013 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх:**

- ✚ Хөвсгөл аймгийн ДЦС барихаар тендерт шалгарсан АНУ сервис ХХК 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдөр ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан бөгөөд хугацааг нэг жил хэтрүүлсэн ба энэ оны 10 дугаар сарын 8-нд техникийн комисс ажилласан боловч улсын комисс хүлээж аваагүй атал станцыг ажиллуулж эхэлсэн;
- ✚ Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Хэрх тосгоны 35\6 кВт-ын дэд станц барих”;
- ✚ Дархан хотын 110\6 кВт-ын давхар дэд станцын 110 кВт-ын ил, 6 кВт-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх ажлуудыг улсын комисст хүлээлгэж өгөөгүй;

**2014 онд ашиглалтад оруулах:**

- ✚ ДЦС-2 ТӨХК-ийн зуухны шинэчлэл”-ийн ажлыг (3.0 тэрбум төгрөг) МЭЗ ХХК 2014 оны 4 дүгээр сарын 01-нд ашиглалтад оруулахаар ( гэрээ сунгасан) гэрээ байгуулсан боловч өнөөдрийг хүртэл хийж дуусаагүй;
- ✚ Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 35 кВт-ын 135 км ЦДАШ, дэд станцын ажил;
- ✚ ДЦС-2-ын ТС-35-39 зуух №1, 3-т үнс барих, цахилгаан шүүлтүүр суурилуулах;
- ✚ ДЦС-4-ийн зуухнуудын үнс, утааны хийн ялгаруулалтыг бууруулах, технологи нэвтрүүлэхээр МЭЗ ХХК-ийн гүйцэтгэж энэ оны 6-7 дугаар сард ашиглалтад оруулах;
- ✚ Өвөрхангай аймгийн Хархорин, Хөвсгөл аймгийн Мөрөн дэд станцад тус бүр 2 ком 6, 10 кВт-ын удирдлагатай реакторын, Сайншанд дэд станцад 2 ком 35 кВт-ын синхрон компинсатор суурилуулах ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэж байгаа ажил;
- ✚ Умард дэд станцаас кабель шугам татаж, 6 дугаар бичил хороололд шинээр 10 кВт-ын хуваарилах байгууламж, УБ хотын 1 дүгээр хорооллын ТП5 –ын дэргэд 10 кВт-ын хуваарилах байгууламж шинээр барих Электрик ком ХХК-ийн гүйцэтгэж байгаа ажил;
- ✚ Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах төсөл, арга хэмжээний Хайрхан Наран Трейд ХХК-ийн гүйцэтгэж байгаа 2 багц арга хэмжээ;
- ✚ Иррадианс ХХК-ийн гүйцэтгэж буй 1 багц ажлуудын гэрээний хугацаа дууссан боловч улсын комисс ажиллаагүй байна.

3.3 2014 онд ашиглалтад орох объектоос Өвөрхангай аймгийн Хархорин, Хөвсгөл аймгийн Мөрөн дэд станцад тус бүр 2 ком 6, 10 кВт-ын удирдлагатай реакторын, Сайншанд дэд станцад 2 ком 35 кВт-ын синхрон компинсатор суурилуулах ЦДҮС-ТӨХК-ийн гүйцэтгэж байгаа ажил 30 хувьтай бусад ажил 90 хувьтай байна.

3.4 Мөн 2013 оны улсын төсвийн хөрөнгөөр ДЦС-2 ТӨХК нь “Зуухны шинэчлэл” барилга угсралтын ажлыг тухайн оны 12 дугаар сарын 31-нд ашиглалтад оруулахаар МЭЗ ХХК-тай 3.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, угсралтыг хийж дууссан боловч галлагааны системийн сонголтоос шалтгаалан туршилтыг эцэслэн шийдвэрлээгүйгээс ашиглалтад оруулах хугацааг 259 хоногоор хоцроогоод байна.

3.5 Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгөөр эрчим хүчний салбарт 2013 онд 72.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 3 төсөл хэрэгжүүлэхээр баталсан бол 2014 онд төсөвт өртөг 2.1 дахин өсч 151.4 тэрбум төгрөг болж өсчээ. Үүнд,

- ✚ Дэд бүтэц-Эрчим хүч төсөлд 2013 онд 68.8 тэрбум төгрөг баталсан бол 2014 онд 117.4 тэрбум;
- ✚ Эгийн голын усан цахилгаан станц төсөлд 2013 онд 0.9 тэрбум баталсан бол 2014 онд 12.1 тэрбум;
- ✚ Таван толгойн цахилгаан станц төсөлд 2013 онд 3.2 тэрбум төгрөг баталсан бол 2014 онд 21.9 тэрбум болж тус тус өссөн байна.

3.6 Дэд бүтэц-Эрчим хүч төсөлд 2013 онд 1.1 тэрбум, 2014 онд 0.5 тэрбум, Эгийн гол усан цахилгаан станц төсөлд 2013 онд 0.8 тэрбум, 2014 онд 3.3 тэрбум, Таван толгойн цахилгаан станц төсөлд 2013 онд 2.9 тэрбум, 2014 онд 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн байна.

3.7 **Бондын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд:** техникийн нөхцөл аваагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ бэлэн болоогүй цөөнгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал,

- ✚ Дэд бүтэц-эрчим хүч төслийн хүрээнд хийгдэж буй 14.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 4 км шугамын ажлын зураг төсөл, төсөвт өртгийг бодитой тооцоогүйгээс 6.5 тэрбум төгрөгөөр төсөвт өртөг нэмэгдсэн;
- ✚ Яармагийн гүүр орчмын хорооллын 110\35\10 кВт-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил 110 кВт-ын АС-240\39 дамжуулагч утастай, 2х2 шилэн кабель бүхий аянгын тросстой ЦДАШ-ын зураг төсөл, барилга угсралтын 7.3 тэрбум төгрөгийн ажлын техникийн нөхцөл шийдэгдээгүй;
- ✚ Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсонтой холбогдуулж СХД-ийн ханын материал орчмын гэр хорооллын дулааны 1.1 км шугам, ус дамжуулах төв, 137 м шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны 21.2 км, бохир усны 1.8 км шугамын 9.8 тэрбум төгрөгийн ажил хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон байна.

3.8 **Байгууллагын хөрөнгөөр гүйцэтгэсэн хөрөнгө оруулалт:** ДЦС-4 ТӨХК БНХАУ-ын АНЕНГ Цахилгаан станцын тоног төхөөрөмж групптай 3.9 сая ам.долларын өртгөөр төмөр бетонон хийцтэй “Хөргөх цамхаг 4”-ийг 2011 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 2011 оны 10 дугаар сарын 31-ний өдөр дуусгахаар гэрээ байгуулсан боловч хүйтний улирлаас шалтгаалан гэрээг сунгасан ч 115 хоногоор хугацаа хоцроож, 2012 оны 10 дугаар сарын 25-нд ашиглалтад оруулжээ.

3.9 Ашиглалтын явцад хөргөх цамхагийн дээд хэсгээр гадагш хөлдөлт үүсэх, чийг баригчууд нурах, ус хөргөөх төхөөрөмжийн зарим хэсэгт эвдрэл, хагарал гарч, баталгаат хугацаа дуусаагүй учраас гүйцэтгэгч цамхагийн дотор гадна талыг хамгаалалтын будгаар будсан ч энэ онд дээрх гэмтэл дахин гарчээ.

3.10 Гэтэл инженерийн дээрх байгууламжийг барих зөвшөөрлийг МХЕГ-аас аваагүй, экспертизээр баталгаажуулаагүй зураг төсвөөр гүйцэтгэснээс шалтгаалан улсын комисст хүлээлгэн өгөөгүй байна.

3.11 Энэ нь тус станцын үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж аваарын зогсолт үүсэх нөхцлийг бий болгож, хөрөнгө оруулалтыг үр ашиггүй, бүрэн дүүрэн ашиглаж чадаагүйгээс дахин хөрөнгө шаардагдах асуудал үүсч байна.

3.12 Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ууд улсын төсөв, Засгийн газрын бонд, өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс хэрэгжилт удааширч, он дамжиж байгаагийн зэрэгцээ, чанарын шаардлага хангахгүй нөхцөл байдал бий болжээ.

**Төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан зөрчил гарсан байна**

3.13 Эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-уудын худалдан авалтын төлөвлөгөөг ТӨХ-ноос баталдаг бөгөөд үнэ, тарифын өөрчлөлт, орлогоос шалтгаалан жил бүр тодотгол хийгддэг байна.

(сая төгрөг)

ТӨХК	2013 оны эхэнд батлагдсан			2013 оны тодотгол			Зөрүү нэмэгдсэн, хасагдсан		
	ХО	ИЗ	ТЗБАХ	ХО	ИЗ	ТЗБАХ	ХО	ИЗ	ТЗБАХ
ДЦС-2	216.8	1027.9	139.2	163.8	1126.4	94.2	-53.0	98.5	45.0
ДЦС-3	1329.0	5695.0	319.0	1329.0	5739.6	319.0	-	43.6	-
ДЦС-4	2534.9	12500.0	9766.4	1042.9	8808.9	8929.9	-1492.0	-3691.1	-836.5
ЦДҮС	1161.3	831.6	3449.7	1234.1	853.1	3532.1	72.8	21.5	82.4
УБЦТС	4743.2	2298.0	2543.4	4164.9	1969.2	4347.7	-578.3		
УБДС	1284.5	5758.8		1273.4	5769.9		-11.1	11.1	
<b>Нийт</b>	<b>11269.7</b>	<b>28111.3</b>	<b>16217.7</b>	<b>9208.1</b>	<b>24267.1</b>	<b>17222.9</b>	<b>-2061.6</b>	<b>174.7</b>	<b>127.4</b>
								<b>-3691.1</b>	<b>-836.6</b>

3.14 ТӨХ төрийн өмчит ААНБ-ын төсвийг дараа оны 3-5 сарын хооронд баталдагаас төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийх асуудал үүсдэг байна.

3.15 ӨБЦТС ТӨХК “Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх сан” ТББ-тай нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын гэрээг худалдан авах ажиллагааны эрх үүсэхээс 20 хоногийн өмнө 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан байлаа.

3.16 ТБОНӨХБАҮХАТХ-ийн заалтыг зөрчиж гэрээ шууд байгуулах аргаар бараа, түүхий эд материал худалдан авсан байна. Тухайлбал,

- ✚ ДЦС-2 компани 77.8 сая;
- ✚ БЦТС компани 53.5 сая;
- ✚ ББЭХС 1392.3 сая;
- ✚ Даланзадгад дулааны цахилгаан станц 287.2 сая;
- ✚ ЭБЦТС компани 143.5 сая төгрөг.

3.17 ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч зайлшгүй ажлын шаардлагаар тусгай зориулалтын зарим бараа, түүхий эд материалыг шууд худалдан авах асуудал гардаг байна. Тухайлбал,

- ✚ ДЦС-4 компани нь 2013 онд ХБНГУ, ОХУ, БНХАУ-аас тусгай зориулалтын сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, түлш, түүхий эд материал 1207.3 сая;
- ✚ УБЦТС ТӨХК 34.0 сая төгрөг;
- ✚ ДЦС-3 ТӨХК 164.7 сая;

3.18 Мөн бараа, ажил үйлчилгээний худалдан авсан гэрээг дүгнээгүй, алданги тооцоогүй гэрээний үнийн дүн хэтэрсэн зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал,

ДЦС-2 ТӨХК

- ✚ 87.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд гэрээ байгуулж, дүгнээгүй, нэхэмжлэхгүйгээр мөнгө шилжүүлсэн;
- ✚ 319.5 сая төгрөгийг гэрээг дүгнэлгүйгээр шууд шилжүүлсэн;
- ✚ Гэрээний хугацааг 7-120 хоногоор хоцроосон 15 компанид гэрээг дүгнэж алданги тооцоогүй байлаа.

ДЦС-3 ТӨХК

- ✚ 23.8 сая төгрөгөөр худалдан авсан барааны гэрээний үнийн дүн хэтэрсэн;

УБЦТС

- ✚ Дары солнце ХХК-иас 89.6 сая төгрөгийн ажлын хувцас авах гэрээ байгуулан 107.7 сая төгрөгийн бараа нийлүүлж, 18.1 сая төгрөгийн худалдан авалт илүү хийсэн байлаа.

3.19 ТЭХС-ын (хуучнаар) 2006 оны 5 дугаар тушаалын дагуу эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх чиглэлээр тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэн байна.

3.20 Улсын хэмжээнд давхардсан тоогоор цахилгааны чиглэлээр 261, дулааны чиглэлээр 157, цахилгаан, дулаан хосолсон тусгай зөвшөөрөл авсан 222 аж ахуйн нэгж, байгууллага, үүний дотор төвийн эрчим хүчний системийн чиглэлээр ажил үйлчилгээ явуулах 29 аж ахуйн нэгж байна.

3.21 Гэтэл эрчим хүчний салбарын төрийн өмчит ААНБ-ууд хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулахдаа цөөн тооны компаниудаар гүйцэтгүүлж иржээ. Тухайлбал,

- ✚ ДЦС-4, ДЦС-3 компаний хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэгчээр МЭЗ ХХК, Хасумегаватт ХХК, Аморе интернешнл ХХК, Эрчим маш ХХК, Альянс тех ХХК, Намир инвест ХХК, Эрчим сервис ХХК-ууд шалгардаг байна.

3.22 Энэ бүхнээс үзэхэд ХАА-ны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг сайжруулах шаардлагатай байна.





**Үйлдвэрлэлийн дотоод хяналт хэвийн явагдаж байна**

3.23 Төрийн өмчит компаниудын хувьд дотоодын хяналтын алба, хэлтэстэй ажиллаж ирснээс төвийн эрчим хүчний систем дэх ДЦС-4, ДЦС-3, ДЦС-2, ДҮТ, ЦДҮС, УБДС ТӨХК-иуд нь үйлдвэрлэлийн найдвартай, тасралтгүй, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалтад тавих хяналтыг тодорхой түвшинд гүйцэтгэж ирсэн байна.


3.24 Харин УБЦТС компанид гадны байгууллага, иргэдийн үйл ажиллагаанаас шалтгаалан дараах хүндрэл гардаг байна. Тухайлбал,

- ✚ Гадны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн буруутай үйлдлээс шалтгаалан 2011 онд 72 шугам, тоноглол гэмтэж байсан бол 2014 оны байдлаар 121 болж өсчээ. Үүнээс шалтгаалан зөвхөн шугам холбоход 2013 онд 131.7 сая, 2014 оны эхний 10 сарын байдлаар 90.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, мөн иргэдэд хүргэх үйлчилгээ, борлуулалтыг бууруулдаг байна.

3.25 Сүүлийн жилүүдэд ялангуяа Газрын тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотой эрчим хүчний шугам сүлжээ, дэд станцын хамгаалалтын зурвас, агаарын шугамын трансн дор, кабель шугамын транс дээр дэд станцын дэргэд айл, өрх, аж ахуйн нэгжүүд их хэмжээгээр суурьшиж байна.Тухайлбал

-  Хамгаалалтын зурвасын зөрчилтэй хэрэглэгчид 3543;
-  35 кВт-ын станцыг тойруулан хашаа барьсан;
-  Чингэлтэй дүүрэгт ХТП-384, ХТП-266 хоорондох 6 кВт-ын транс дээр үйлчилгээний барилга барьсан;
-  35 кВт-ын агаарын шугамын дор автомашины зогсоол ажиллуулж байгаа зөрчил байна.

3.26 Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудад дотоод аудиторын орон тоог бий болгон ажиллаж байгаа боловч ажилтнуудын ур чадвар, мэргэжил мэдлэгээс шалтгаалан харилцан адилгүй үр дүнг үзүүлж байна.Тухайлбал,

-  УБДС ТӨХК-ийн дотоод аудитор нь 2013 онд компанийн борлуулалтын үйл ажиллагаа, хэрэглэгчээс авах орлогын эх үүсвэр, хэмжүүрийн ашиглалтын үр дүнд аудит хийснээр 177.8 сая төгрөгийн орлогыг нэмж оруулсан байлаа.

3.27 Гэтэл зарим компаниудын хувьд дотоод аудиторын үүрэг төдийлэн харагдахгүй байна.

3.28 Эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар ҮАГ-аас 1532.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5200.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, аудитын явцад 522.7 сая төгрөгийн актыг барагдуулж, улсын төсөвт орууллаа.


3.29 Харин аймаг, нийслэлийн аудитын газар 114.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 12043.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.(Хавсралт №5)


**ДҮГНЭЛТ**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:**

- ✚ УИХ-аас эрчим хүчний салбарын эдийн засгийн чадавхийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.
- ✚ Монгол Улсын эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 0.8 хувийг эзэлж буй Клин Энержи ХХК-ийн Салхит СЦС-аас худалдан авч байгаа 1 кВтц цахилгаан эрчим хүчний үнэ төвийн бүсийн цахилгаан станцуудын дундаж үнээс 2.4 дахин буюу 92.2 төгрөгөөр өндөр байна.
- ✚ Холбогдох хуульд заасны дагуу Салхит СЦС-аас нийлүүлж буй цахилгаан эрчим хүчний төлбөрийг ам.доллараар хийж байгаагаас 2014 оны байдлаар ханшийн зөрүүгээр 320.1 сая төгрөгийн алдагдал хүлээж байна.
- ✚ ОХУ-аас импортоор авч байгаа цахилгаан эрчим хүчний үнийг рублиэр тооцож, төлбөрийг ам.доллараар хийж байгаагаас шалтгаалан цахилгаан эрчим хүчний төлбөр 2013 онд 10.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- ✚ “Нэг худалдан авагч”-ийн “0.0” үлдэгдэлтэй дансны өглөг 2013 оны эхэнд 12.1 тэрбум төгрөг байсан бол 2014 оны эхэнд 20.8 тэрбум төгрөг болж 1.7 дахин өсөхөд дээрх 2 зүйл голлож нөлөөлсөн байна.
- ✚ Хэрэглэгч, айл өрх, аж ахуйн нэгжид худалдах эрчим хүчний үнэ тарифт Эрчим хүчний зохицуулах хорооноос 2014 онд 3 удаа өөрчлөлт оруулснаар эрчим хүчний суурь үнэ дунджаар 16.2 хувиар өсчээ.
- ✚ Эрчим хүчний салбарын аудитад хамрагдсан 25 аж ахуйн нэгж, байгууллагаас эрчим хүч үйлдвэрлэгч 18 нь алдагдалтай, тусгай зөвшөөрөл олгодог, зохицуулагчийн үйлчилгээний хөлс авдаг, зураг төслийг боловсруулдаг, хяналт тавьдаг байгууллагууд ашигтай ажилласан байна.
- ✚ Эрчим хүчний салбарт удирдах, зохицуулах, судалгаа шинжилгээ, хяналт шалгалт хийх, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа ЭХЯ, ЭХЗХ, ЭХХТ, ДҮТ зэрэг байгууллагуудын чиг үүрэгт давхардсан, орон тоо нүсэр, зардал өндөр байна.
- ✚ Тус салбарт улсын төсөв болон бусад эх үүсвэрээс хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хугацаандаа хэрэгжээгүй, үр ашиггүй төсөл, арга хэмжээ цөөнгүй байна.

Холбогдох байгууллагын санал

<p><b>ҮАГ-ын тайлбар</b></p> <p>Тайлбар 1-ийг үзнэ үү</p> <p>Тайлбар 2-ыг үзнэ үү</p> <p>Тайлбар 3-ыг үзнэ үү</p>	<div style="text-align: center;">  <p>МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ</p> <p><b>МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ</b></p> <p>17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр, Утас: 6226-3051, Факс: (976) 7094-3479</p> <p>2015.01.12 № 6/62 танай _____-ны № _____-г</p> </div> <p>Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аудитын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу "Эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа үр дүн"-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Аудитын тайланд:</p> <p>Тайлангийн төслийн 3 дугаар бүлэгт /Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагад хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын үр өгөөж хангалтгүй байна/ тусгагдсан Булган аймгийн дулааны шугамын өргөтгөл, Хөвсгөл аймгийн дулааны станц барих, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны 35/6 кВ-ын дэд станц барих, ДЦС-2-ын зуухны шинэчлэлт, Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын 135 км ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх, ДЦС-2-ын ТС-35-39 зуух №1, 3-т үнс барих цахилгаан шүүлтүүр суурилуулах, ДЦС-4-д зуухнуудын үнс, утааны хийн ялгаруулалтыг бууруулах технологи нэвтрүүлэх, Улаанбаатар хотын хаалттай хуваарилах байгууламж-7-ийн хүчин чадал нэмэгдүүлэх, өргөтгөх, Улаанбаатарын Умард дэд станцаас кабель шугам татаж 6 дугаар бичил хороололд 10 кВ-ын хуваарилах байгууламж шинээр барих, 1 дүгээр хорооллын ХТП-5-ын дэргэд 10 кВ-ын хуваарилах байгууламж шинээр барих, Улаанбаатарын гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах төсөл арга хэмжээний багц 1, 2, 5-ын ажлууд нь аудит хийсэн хугацаанаас хойш 2014 онд багтан ашиглалтад орсон болно.</p> <p>Зөвлөмжид 2010 оны УИХ-ын 72 дугаар тогтоолын хэрэгжилтийн хугацаа дуусч 2014 оны УИХ-ын 34 дүгээр тогтоолын хавсралт "Эдийн засгийн идэвхижлийг нэмэгдүүлэх арга хэмжээний 4.2-т заасан байна.</p> <p>Эрчим хүчний салбарын цахилгаан, дулааны үнэ тарифыг төрөөс зохицуулж байгаа тул цахилгаан, дулааны үнэ тарифыг чөлөөлж чадахгүй байна. Эрчим хүчний салбарын мөнгөн урсгалыг зохицуулж байгаа "Нэг худалдан авагч" загварыг шинэчлэн зах зээлд нийцсэн шинэ загварыг нэвтрүүлэх.</p> <p style="text-align: right; color: red;">008000080</p>
---	--

<p>Тайлбар 4-ийг үзнэ үү</p> <p>Тайлбар 5-ыг үзнэ үү</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 186 дугаар тогтоолын 5,6 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар Сангийн яам, Төрийн өмчийн хороо, Эрчим хүчний зохицуулах хороонд зөвлөмж болгон оруулах саналтай байна.</p> <p>?          Тус тайланд "Эрчим хүчний дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар тусгагдсан зарим мэдээлэл, дүгнэлт бодит байдлаас зөрүүтэй байгааг анхааралдаа авч залруулах талаар хамтран ажиллахыг хүсье.</p> <p>Хавсралтаар "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр"-ийн тайлан, Засгийн газрын 2013 оны 118 дугаар тогтоолын хүрээнд Эрчим хүчний салбарт хийгдэж байгаа төслийн ажлын тайлбарыг тус тус хүргүүлж байна.</p> <p>Хавсралт <i>42</i> хуудастай.</p> <div style="text-align: center;">  <p>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА <span style="float: right;">Д.ДЭЛГЭРЦОГТ</span></p> </div>
--	---



## Тайлбар

### Эрчим хүчний яамнаас ирүүлсэн санал

Тайлбар 1	Аудит хийсэн хугацаанаас хойш ашиглалтад орсон учраас тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.
Тайлбар 2	Саналыг хүлээн авлаа.
Тайлбар 3	Тайланд тусгагдсан байна
Тайлбар 4	Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгалаа
Тайлбар 5	Саналыг хүлээн авлаа

**ЗӨВЛӨМЖ**

**Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:**

**Эрчим хүчний сайдад:**

1. Эрчим хүчний салбарын найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх талаар гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;
2. Цахилгаан эрчим хүчний худалдан авалтын төлбөр тооцоонд валютын ханшаас шалтгаалж үүссэн алдагдал, өр төлбөрийг бууруулах, цаашид ийм төрлийн эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авах;
3. Эрчим хүчний үйлдвэрлэлд гарч байгаа бодит өртгийг нөхөх, ашигтай ажиллах, “0.0” үлдэгдэлтэй дансанд үүссэн авлага, өглөгийг цэгцлэх чиглэлээр үнэ тариф, төлбөр тооцооны журам, арга зүйг боловсронгуй болгох асуудлыг судалж шийдвэрлэх;
4. Салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн бүх шатанд хууль эрх зүйн шаардлагыг хангах, үүрэг хариуцлагыг чангатгах, хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
5. Эрчим хүчний зохицуулах хороо, Диспитчерийн үндэсний төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн зэрэг байгууллагуудын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, орон тоо зардал хэмнэх боломжийг судалж, холбогдох арга хэмжээ авах.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах  
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5 дахь заалт, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөрийн акт, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний яам болон холбогдох байгууллагуудад хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2015 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний сайд Д.Зоригтод зөвлөсүгэй.
5. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Төмөрхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР А.ЗАНГАД



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 31 дүгээр тушаалын хавсралт

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцагч байгууллага	Төлбөр зөрчлийн товч утга	Аудитор, шинжээчийн нэр	Актны дугаар	Төлбөрийн дүн	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн	(сая төгрөгөөр)		
								Аудитын явцад барагдуулсан	Аудитын явцад барагдуулсан	
1	ДУТ ТӨХК	Зээл нөхөн төлүүлэх тухай	Д.Цэрэндорж	01/31	296.7			296.7		
2	УБЦС ТӨХК	Зээл төлүүлэх тухай	Д.Цэрэндорж Г.Гунжидмаа	01/32	1208.9			200		
3	ДЦС-3 ТӨХК	Төлөвлөгдөөгүй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсныг нөхөн төлүүлэх тухай	С.Сэрхорол Ж.Оюунтуяа	01/38	11.3			11.3		
4	"ЭХХТ" ТӨААТҮГ			01/40	8.4			8.4		
5	ЦДҮС ТӨХК	Хөргөх цамхаг-4-ийн үйл ажиллагааг хэвийн болгох	С.Сэрхорол Ж.Оюунтуяа	01/39	6.3			6.3		
6	ДЦС-4 ТӨХК						02/87	5200.0		
<b>НИЙТ ДҮН</b>								<b>1531.6</b>	<b>5200.0</b>	<b>522.7</b>

(Хавсралт №1)

Хэрэглэгчдийн цахилгааны тарифын өөрчлөлтийн судалгаа

(төгрөгөөр)

Хэрэглэгчийн ангилал		Тарифын өөрчлөлтүүд				харьцуулалт		
	Тогтоол баталсан огноо	14.07.21	14.08.05	14.11.19	14.08.10 / 11.05.01	14.09.15 / 11.05.01	14.12.05 / 11.05.01	
	Тогтоолын дугаар	97	119	192				
	Мөрдөж эхлэх огноо	11.05.01	14.08.10	14.09.15	14.12.05			
<b>1</b>	<b>Уул уурхай олборлох, боловсруулах аж үйлдвэр</b>							
1.1	Энгийн тоолууртай	100.00	135.00	138.00	151.60	1.35	1.38	1.52
1.2	3 тарифт тоолууртай							
	а. Өдрийн хэрэглээ	100.00	135.00	138.00	151.60	1.35	1.38	1.52
	б. Оройн хэрэглээ	179.40	239.00	244.00	271.70	1.33	1.36	1.51
	в. шөнийн хэрэглээ	46.00	65.00	66.30	72.80	1.41	1.44	1.58
<b>2</b>	<b>Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага</b>							
2.1	Энгийн тоолууртай	88.00	110.60	113.00	124.20	1.26	1.28	1.41
2.2	3 тарифт тоолууртай							
	а. Өдрийн хэрэглээ	88.00	110.60	113.00	124.20	1.26	1.28	1.41
	б. Оройн хэрэглээ	155.20	183.00	187.00	205.50	1.18	1.20	1.32
	в.шөнийн хэрэглээ	46.00	65.00	66.30	72.80	1.41	1.44	1.58
2.3	Цахилгаан тээвэр ХК	49.20	65.00	66.30	72.80	1.32	1.35	1.48
<b>3</b>	<b>УБ хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны хэлэлцүүлэг</b>							
3.1	10.11.12.1.2.3 -р саруудад							
	а. Өдрийн хэрэглээ		110.60	113.00	124.20		1.02	1.10
	б. Орой, шөнийн хэрэглээ		65.00	66.30	72.80		1.02	1.10
3.2	4.5.6.7.8.9-р саруудад							
	а. Өдрийн хэрэглээ		110.60	113.00	124.20		1.02	1.10
	б. Орой, шөнийн хэрэглээ		65.00	66.30	72.80		1.02	1.10
	<b>Айл өрхөд борлуулах цахилгааны тариф</b>							
	<b>Энгийн тоолууртай</b>							
	Сарын нийт хэрэглээний 150 кВт цаг хүртэлх хэрэглэгээг	74.00	84.00	85.70	94.10	1.14	1.16	1.27
	Сарын нийт хэрэглээний 150 кВт цаг болон түүнээс дээших хэрэглэгээг	84.00	101.60	103.60	113.90	1.21	1.23	1.36
	<b>2 тарифт тоолууртай</b>							
	а. Өдрийн хэрэглээ	84.00	89.00	91.00	100.00	1.06	1.08	1.19
	б. Оройн хэрэглээ	40.00	65.00	66.30	72.80	1.63	1.66	1.82
	Сарын суурь тариф		1,000.00	1000.00	1000.00		1.00	1.00
	<b>Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээ</b>							
			350.00	350.00	350.00		1.00	1.00
	Энгийн тоолууртай		1.22	1.22	1.22			
	3 тарифт тоолууртай							
	а. Өдрийн хэрэглээ		1.22	1.22	1.22			
	б. Оройн хэрэглээ		1.31	1.30	1.32			
	в.шөнийн хэрэглээ		1.00	1.00	1.00			
	Сарын нийт хэрэглээний 150 кВт цаг 6		1.21	1.21	1.21			
	2 тарифт тоолууртай		0.88	0.88	0.88			

(Хавсралт № 2)

Төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифын судалгаа

Нэг. Улаанбаатар хотын хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Улаанбаатар хот				Харьцууллт		
			11 IV/12	13 VII/05	14 VIII/15	14 XI/19	13.VII.5 / 11.IV.12	14.VIII.15 / 11.IV.12	14.XI.19 / 11.IV.12
	Тогтоол баталсан огноо								
	Мөрдөж эхэлсэн огноо		11 V/01	13 VIII/05	14 IX/15	14 XII/05			
	Тогтоолын дугаар		15	70	118	194			

Нэг. Аж ахуйн нэгж байгууллагад

1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м <sup>3</sup>	323	323	330	373	1.00	1.02	1.15
2	Хэмжүүрээр тооцох дулаан	Төг/Гкал	20,886	20,886	21,310	24,080	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	4,989	4,989	5,090	5,752	1.00	1.02	1.15
3	Салхилуулга	Төг/Гкал	10,632	10,632	10,842	12,255	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	2,539	2,539	2,590	2,927	1.00	1.02	1.15
4	Албан байгууллагын ХХУ халаасан дулаан	Төг/хүн	4,084	4,084	4,166	4,708	1.00	1.02	1.15
		Төг/м <sup>3</sup>			1,326	1,498			
5	Технологийн халуун ус	Төг/Гкал	10,632	10,632	10,845	12,255	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	2,539	2,539	2,590	2,927	1.00	1.02	1.15

Хоёр. Айл өрхөд

1	Орон сууцны халаалт	Төг/м <sup>2</sup>	341	341	348	400	1.00	1.02	1.17	
		Төг/Гкал	7,879	7,879	8,040	9,085	1.00	1.02	1.15	
		Төг/ГДж	1,882	1,882	1,920	2,170	1.00	1.02	1.15	
2	Ахуйн ХХУ халаасан дулаан	Хал. улиралд	Төг/хүн	1,282	1,282	1,308	1,478	1.00	1.02	1.15
		Хал. бус улиралд	Төг/хүн	1,924	1,924	1,963	2,218	1.00	1.02	1.15
		Усны зарцуулалтаар	Төг/м <sup>3</sup>			1,050	1,187			1.13
		Хэмжүүрээр	Төг/Гкал	9,824	9,824	10,021	11,324	1.00	1.02	1.15
			Төг/ГДж	2,346	2,346	2,393	2,704	1.00	1.02	1.15
3	40 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	-	3,000	3,000	3,000		1.00	1.00	
	41 м <sup>2</sup> -аас 80 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	-	5,000	5,000	5,000		1.00	1.00	
	81 м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	-	10,000	10,000	10,000		1.00	1.00	

Хоёр. Дархан-Уул аймгийн Дархан сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Дархан хот				Харьцууллт		
			11 IV/12	13 VII/05	14 VIII/15	14 XI/19	13.VII.5 / 11.IV.12	14.VIII.15 / 11.IV.12	14.XI.19 / 11.IV.12
	Тогтоол баталсан огноо								
	Мөрдөж эхэлсэн огноо		11 V/01	13 VIII/05	14 IX/15	14 XII/05			
	Тогтоолын дугаар		16	71	119	195			

Нэг. Аж ахуйн нэгж байгууллагад

1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м <sup>3</sup>	298	298	304	373	1.00	1.02	1.25
2	Хэмжүүрээр тооцох дулаан	Төг/Гкал	16,600	16,600	16,932	20,318	1.00	1.02	1.22
		Төг/ГДж	3,965	3,965	4,045	4,854	1.00	1.02	1.22
3	Технологийн халуун ус	Төг/Гкал	9,180	9,180	9,364	11,237	1.00	1.02	1.22
		Төг/ГДж	2,192	2,192	2,236	2,683	1.00	1.02	1.22
4	Салхилуулга	Төг/Гкал							
5	Албан байгууллагын ХХУ халаасан дулаан	Төг/хүн	3,142	3,142	3,205	3,846	1.00	1.02	1.22
		Төг/тн	1,045	1,045	1,066	1,279	1.00	1.02	1.22
		Төг/Гкал	6,848	6,848	6,985	11,237	1.00	1.02	1.64
		Төг/ГДж	1,636	1,636	1,669	2,683	1.00	1.02	1.64
6	Буцаагүй конденсат	Төг/Гкал	1,664	-	-	-			
		Төг/ГДж	398	-	-	-			
7	Уур 0.8-1.3 МПа	Төг/Гкал	18,222	20,000	20,400	23,052	1.10	1.12	1.27
		Төг/ГДж	4,352	4,777	4,873	5,506	1.10	1.12	1.27
8	Уур 2.0 МПа	Төг/Гкал	18,794	24,500	24,990	28,239	1.30	1.33	1.50
		Төг/ГДж	4,489	5,852	5,969	6,745	1.30	1.33	1.50
9	Сүлжээний усны алдагдал	Төг/тн	2,635	-	-	-			

<b>Хоёр. Айл өрхөд</b>									
1	Орон сууцны халаалт	Төг/м <sup>2</sup>	341	341	348	400	1.00	1.02	1.17
		Төг/Гкал	7,879	7,879	8,040	9,085	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	1,882	1,882	1,920	2,170	1.00	1.02	1.15
2	Ахуйн ХХУ халаасан дулаан	Хаалттай Төг/хүн	1,282	1,282	1,308	1,478	1.00	1.02	1.15
		Нээлттэй Төг/хүн	1,924	1,924	1,963	2,218	1.00	1.02	1.15
3	40 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	-	3,000	3,000	3,000		1.00	1.00
	41 м <sup>2</sup> -аас 80 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл	Төг/сар	-	5,000	5,000	5,000		1.00	1.00
	81 м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	-	10,000	10,000	10,000		1.00	1.00
<b>Гурав. Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф</b>									
№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Эрдэнэт хот				Харьцуулалт		
	Тогтоол баталсан огноо		11 IV/12	13 VII/05	14 VIII/15	14 XI/19			
	Мөрдөж эхэлсэн огноо		11 V/01	13 VIII/05	14 IX/15	14 XII/05	13.VII.05\ 11.IV.12	14.VIII.15 / 11.IV.12	14.XI.19 / 11.IV.12
	Тогтоолын дугаар		17	72	120	196			
<b>Нэг. Аж ахуйн нэгж байгууллагад</b>									
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м <sup>3</sup>	345	345	352	398	1.00	1.02	1.15
2	Хэмжүүрээр тооцох дулаан	Төг/Гкал	22,556	22,556	23,008	25,999	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	5,387	5,387	5,495	6,209	1.00	1.02	1.15
3	Салхилуулга	Төг/Гкал	8,730	8,730	8,905	10,063	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	2,085	2,085	2,127	2,404	1.00	1.02	1.15
4	Албан байгууллагын ХХУ халаасан дулаан	Төг/хүн	4,538	4,538	4,629	5,231	1.00	1.02	1.15
5	Конденсат	Төг/Гкал	1,286	-	-	-			
		Төг/ГДж	307	-	-	-			
6	Технологийн уур	Төг/Гкал	21,123	24,500	24,990	28,239	1.16	1.18	1.34
		Төг/ГДж	5,045	5,852	5,969	6,745	1.16	1.18	1.34
7	Сүлжээний усны алдагдал	Төг/тн	2,203	-	-	-			
<b>Хоёр. Айл өрхөд</b>									
1	Орон сууцны халаалт	Төг/м <sup>2</sup>	341	341	348	400	1.00	1.02	1.17
		Төг/Гкал	7,879	7,879	8,040	9,085	1.00	1.02	1.15
		Төг/ГДж	1,882	1,882	1,920	2,170	1.00	1.02	1.15
2	Ахуйн ХХУ халаасан дулаан	Хал. улиралд Төг/хүн	1,282	1,282	1,308	1,478	1.00	1.02	1.15
		Хал. бус улиралд Төг/хүн	1,924	1,924	1,963	2,218	1.00	1.02	1.15
3	40 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	-	3,000	3,000	3,000		1.00	1.00
	41 м <sup>2</sup> -аас 80 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл	Төг/сар	-	5,000	5,000	5,000		1.00	1.00
	81 м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	-	10,000	10,000	10,000		1.00	1.00

Хаесралт №3

Эрчим хүчний төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын талаарх судалгаа

№	Байгууллагын нэр	Борлуулалтын орлого		Нийт зардал		Удирдлагын зардал		Хүр аш		Ашиг алдагдал		Тайланг үе аш		Төлөвлөлт		Орон тоо	
		2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013
		(сая төгрөгөөр)															
1	ДЦС-2 ТӨХК	10,276.5	10,858.5	11,962.4	12,198.0	106.0	130.6	(924.3)	(1,714.5)	(1,368.9)	(940.2)	291	278	278	278	2013	
2	ДЦС-3 ТӨХК	59,584.6	64,988.1	65,205.1	66,784.6	132.4	4,517.7	(10,583.6)	(24,093.3)	(6,840.1)	(4,669.6)	960	960	959	959	2013	
3	ДЦС-4 ТӨХК	135,908.6	150,022.7	144,103.2	155,388.7	232.8	1,529.1	(25,861.5)	(27,767.5)	(8,030.0)	(2,811.0)	1,492	1,438	1,462	1,430	2013	
4	Дарханы ДЦС ТӨХК	19,511.8	22,996.9	24,332.8	25,867.4	131.0	149.2	(3,151.5)	(6,167.4)	(3,834.5)	(3,015.9)	432	477	430	477	2013	
5	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	17,958.8	20,904.0	19,355.5	21,650.3	403.5	443.8	(11,376.1)	(13,299.9)	(3,390.7)	(1,923.8)	444.0	446	444	445	2013	
6	Далавцагад ДЦС ТӨХК	1,398.5	1,362.9	4,353.1	3,374.0	583.1	388.3	(7,456.5)	(7,725.8)	(1,217.4)	(1,039.2)	207	207	197	155	2013	
7	Дорнод бүсийн ЭХС ТӨХК	11,249.5	14,927.7	11,897.2	13,092.7	192.9	607.1	(3,362.4)	(6,232.9)	(1,147.1)	(2,045.3)	572	588	581	588	2013	
8	Баруун бүсийн ЭХС ТӨХК /Дөргөн УЦС хамт/	4,990.1	5,739.1	10,970.2	12,110.8	337.0	1,753.9	(1,433.1)	(5,818.2)	(889.2)	(3,563.2)	343	260	342	262	2013	
9	Алтай-Уластай ЭХС ТӨХК	2,150.5	3,260.0	9,218.2	10,619.2	236.3	3,256.4	(3,529.9)	(9,308.8)	(1,783.9)	(5,776.1)	258	278	247	275	2013	
10	ЦДУС ТӨХК	17,963.6	20,493.0	18,605.3	22,151.7	144.3	3,016.2	(12,312.2)	(17,300.1)	(2,120.9)	(3,067.8)	889	970	876	966	2013	
11	УБ ЦТС ТӨХК	144,399.6	168,295.9	124,015.8	148,819.8	122.6	5,887.0	(154,345.1)	(1,997.9)	670.9	10.9	1,661	1,687	1,664	1,713	2013	
12	БЗӨЦТС ТӨХК	25,122.2	26,383.5	17,044.9	25,443.5	389.6	361.1	1,973.7	968.4	238.9	(1,174.7)	476	498	476	484	2013	
13	ӨБЦТС ТӨХК	-	1,173.3	-	1,444.0	-	235.3	-	(414.0)	-	414.0	-	71	0	71	2013	
14	Эрдэнэт-Булганы цөхилгөөн түгээх сүлжээ ТӨХК	86,818.1	96,693.8	79,075.2	87,633.6	1,543.2	11,634.9	(366.8)	(2,631.1)	(2,324.7)	(2,264.3)	575.0	589	581	589	2013	
15	УБ ДС ТӨХК	47,686.3	53,620.9	35,172.4	37,966.2	539.4	13,322.7	(6,952.3)	(4,710.7)	498.7	2,513.8	315	320	311	309	2013	
16	Дарханы дулааны сүлжээ ТӨХК	5,008.6	5,359.0	2,368.6	2,416.6	99.3	3,207.5	821.3	339.2	(14.8)	(480.4)	169	173	167	165	2013	
17	Налайхын дулааны станц ТӨХК	1,143.5	1,478.5	2,862.5	3,927.1	85.1	119.2	(992.6)	(2,036.9)	(218.6)	(827.7)	112	114	114	114	2013	
18	Дулаан Шарын гол ТӨХК	2,971.0	2,883.9	4,390.8	4,523.1	155.1	187.1	(4,713.6)	(4,941.6)	109.0	(228.0)	120	121	121	121	2013	
19	Багажур Дулааны станц ТӨХК	1,284.9	1,961.8	-	-	1,263.7	196.4	(677.6)	(789.8)	(302.3)	(112.1)	57	60	60	60	2013	
20	Эрчим хүчний зохицуулах хороо	1,961.9	2,599.5	1,685.8	1,925.7	791.9	528.9	(36.5)	(139.7)	7.3	53	53	47	42	2013		
21	Диспетчерийн үндэсний төв ТӨҮГ	1,051.9	1,051.9	578.3	578.3	2,556.1	386.7	820.3	199.6	45.7	834.3	-	0	109	2013		
22	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ	3,394.9	921.0	577.6	577.6	56,368.1	5,433.6	(245,084.2)	(136,149.1)	(33,760.9)	(29,752.8)	9,426	9,396	9,394	9,716	2013	
23	Эрчим хүчний хөгжлийн төв	597,388.6	682,967.5	586,619.0	660,344.4	5,433.6	56,368.1	(245,084.2)	(136,149.1)	(33,760.9)	(29,752.8)	9,426	9,396	9,394	9,716	2013	
24	Эрчим корпораци ТӨҮГ	597,388.6	682,967.5	586,619.0	660,344.4	5,433.6	56,368.1	(245,084.2)	(136,149.1)	(33,760.9)	(29,752.8)	9,426	9,396	9,394	9,716	2013	
	Нийт дүн	597,388.6	682,967.5	586,619.0	660,344.4	5,433.6	56,368.1	(245,084.2)	(136,149.1)	(33,760.9)	(29,752.8)	9,426	9,396	9,394	9,716	2013	



Хавсралт № 4

Эрчим хүчний төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын талаарх судалгаа

№	Байгууллагын нэр	Мөнгөн хөрөнгө		Авлага		Баруун материал		Үндсэн хөрөнгө		Богнио хугацаат өр		Урт хугацаат өр	
		2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013
		Авлага		Найд-гүй									
1	ДЦС-2 ТӨХК	464.5	371.5	476.2	715.4	622.9	768.6	34,461.2	11,552.7	1,488.7	2,471.4	911.9	889.9
2	ДЦС-3 ТӨХК	929.5	3,813.2	6,334.6	4,805.2	6,532.2	7,146.9	285,352.1	67,234.2	5,002.8	11,888.0	28,763.5	27,157.8
3	ДЦС-4 ТӨХК	747.6	842.2	7,347.5	8,827.4	11,798.5	13,536.9	861,837.3	279,414.9	11,122.2	8,302.9	87,232.8	185,739.8
4	Дарханы ДЦС ТӨХК	84.4	401.9	1,787.3	2,354.5	2,114.2	2,990.3	87,548.4	55,966.2	4,932.3	6,550.6	9,406.9	23,160.6
5	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	54.1	171.1	686.5	1,200.5	2,078.8	1,817.2	56,984.6	40,253.9	3,241.3	3,111.8	-	-
6	Далайзадгад ДЦС ТӨХК	33.1	19.4	144.5	105.2	691.1	473.1	21,751.9	9,994.3	1,543.3	1,766.2	5,879.5	5,135.7
7	Дорнод бүсийн ЭХС ТӨХК	84.9	40.9	43.0	35.9	955.0	1,050.6	75,842.0	43,795.5	710.3	977.4	12,750.3	12,750.3
8	Баруун бүсийн ЭХС ТӨХК (Дөргөн УЦС хамт)	2,243.4	1,859.9	2,148.3	1,427.3	1,326.9	783.5	87,290.9	75,982.3	1,251.8	1,540.9	44,195.6	44,102.3
9	Алтай-Уластай ЭХС ТӨХК (Тайшир Гуулин УЦС хамт)	2,261.1	704.8	114.9	683.6	869.5	1,787.3	110,897.4	96,411.7	196.9	785.2	43,474.2	43,474.2
10	ЦДЦС ТӨХК	2,543.4	1,966.4	1,114.3	2,086.6	2,834.2	3,064.8	237,281.1	271,463.9	1,843.7	4,091.3	26,455.9	24,726.6
11	УБ ЦТС ТӨХК	1,905.7	1,755.2	27,445.0	11,498.1	4,380.8	7,453.4	171,019.9	64,329.8	12,593.0	13,247.7	42,028.2	49,254.3
12	БЗӨБЦТС ТӨХК	194.7	1,421.6	165.4	1,423.3	693.9	515.9	43,256.9	35,539.0	144.1	3,826.7	19.3	18.3
13	ӨБЦТС ТӨХК		62.8		68.9		70.2		7,195.6		396.8		743.8
14	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	695.6	404.4	538.6	-	1,235.4	1,286.8	35,297.6	45,049.9	4,710.3	6,237.9	-	-
15	УБ ПС ТӨХК	5,487.7	6,464.8	3,503.5	2,873.2	565.2	498.6	174,263.8	82,313.2	1,329.2	1,522.3	31,256.1	27,251.6
16	Дарханы дулааны сүлжээ ТӨХК	23.9	23.0	572.9	-	515.5	396.3	22,047.5	10,925.8	986.9	1,135.6	122.0	-
17	Налайхын дулааны станц ТӨХК	4.3	54.1	179.4	-	470.4	381.4	4,110.7	2,608.9	685.5	1,629.4	-	-
18	Дулаан Шарын гол ТӨХК		17.1		700.7		157.5		966.8		952.2		-
19	Багануур дулааны станц ТӨХК	39.2	17.1	16.3	-	283.3	117.3	5,093.5	3,910.5	1,779.2	2,338.5	-	5.4
20	Эрчим хүчний зохицуулах хороо	288.1	242.8	62.4	-	113.1	28.0	857.1	1,228.7	16.9	101.9	-	-
21	Диспетчерийн үндэсний төв	770.5	614.3	77.0	-	105.9	333.2	10,523.9	10,348.8	411.6	598.8	10,810.5	10,923.9
22	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ	180.2	11.7	39.5	-	80.9	390.7	453.9	432.7	237.9	1.4	-	-
23	Эрчим хүчний хөгжлийн төв		563.5		1,184.2		707.4		6,408.8		960.7		3,731.1
24	Эрчим корпораци ТӨҮГ		39.8		900.3		12.9		128.3		827.0		-
	Нийт дүн	19,035.9	21,883.5	52,797.1	43,694.8	38,553.3	45,495.1	2,328,171.7	1,222,856.4	54,230.9	75,252.6	343,306.7	459,065.6

№	Аймаг, нийслэлийн нэр	Төлбөр харуулагч байгууллагын нэр	Төлбөр, зөрчил хариуцагчийн нэр	Төлбөр зөрчлийн товч утга	Аудитор, шинжээчийн нэр	Акт, албан шаардлагын дүн	Зөрчил	(Хаасралт №5)
								(сая төгрөгөөр)
1	Орхон аймаг	Эрдэнэт Булганы ЦТС ТӨХК	Ч.Баттуяа, Л.Оюунчимэг	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	ТӨХ, ТУЗ-ын зөвшөөрөлгүй байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй худалдан авалт хийсэн	Д.Мягмарсүрэн Б.Буян-Ундрах	14.8	4,964.0
2	Орхон аймаг	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	О.Ганбаатар Ч.Орхон	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Батлагдсан төсвөөс хэтрүүлэн санхүүжүүлсэн	Д.Мягмарсүрэн В.Жавзмаа	2.3	
3	Ховд аймаг	Дөргөн УЦС ХХК	Г.Лхагвасүрэн Э.Оюунбат	Захирал Нягтлан бодогч	Албан томилолт илүү олгосон, гэрээний үнээс илүү санхүүжүүлсэн, жолоочийн тооцонд км илүү бичсэн	Д.Хишгээ	5.9	18.0
4	Увс аймаг	ББЗХС ТӨХК	Ц.Наранчанга Ц.Насанжаргал	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Үнэлэмжийн хорооны гишүүн бус 4 хүнд техник хяналтын зардлаас цалин олгосон	Я.Тунгалаг	10.6	22.0
5	Ховд аймаг	Ховд ЦТС ХХК	Б.Батмөнх Н.Шинэжил	Захирал Нягтлан бодогч	Албан томилолын мөнгийг унаа хоолны мөнгөтэй давхардуулан олгосон	Д.Хишгээ	2.2	8.1
6	НАГ	Багануур ДС ТӨХК	Б.Жаргалсайхан Ц.Энхцэцэг	Гүйцэтгэх захирал Төлөвлөлт, санхүү борлуулалтын хэлтсийн дарга	Түрээсийн төлбөрийн жишиг доод үнээс бага үнээр түрээслэсэн, түрээсийн төлбөрт төвлөрсөн орлогын хувийг төвлөрүүлээгүй	М.Наранжаргал С.Анужин Ц.Ариунболд	1.5	
7	НАГ	Налайхын ДС ТӨХК	М.Өсөхбаяр Б.Доржмаа	Гүйцэтгэх захирал ТСБХ-ийн дарга	Түрээсийн төлбөрийн жишиг доод үнээс бага үнээр түрээслэсэн, түрээсийн төлбөрт төвлөрсөн орлогын 20 хувийг төвлөрүүлээгүй		32.7	
8	Говь-Алтай аймаг	Алтай-Улиастай ЭХС ТӨХК	Г.Чинбат	ЭХСайд	Зээл зориулалт бусаар зарцуулсан	Р.Цанжидмаа Б.Цэцэгмаа	22.0	6,716.2
9	Говь-Алтай аймаг	Тайшир Гуулин УЦС	Ц.Батзориг	Гүйцэтгэх захирал	Арижааны банктэй гэрээ байгуулаагүйгээс хүүний орлого олох боломж алдсан		8.4	30.0
12	Дархан-Уул аймаг	Дарханы дулааны сүлжээ ТӨХК	Б.Алтанцэцэг	Гүйцэтгэх захирал	дараа тайлангаар авсан мөнгөний тайланг хянаж тооцоо үйлдэн санхүүгийн баримтад хавсаргагүй	Г.Цогтбаатар Б.Наранчимэг	12.8	266.1
13	Дархан-Уул аймаг	Дарханы ДЦС ТӨХК	О.Нямдаваа	Гүйцэтгэх захирал	гэрээт хугацаандаа бараа материал нийлүүлээгүй	Г.Цогтбаатар Ч.Гантулга Б.Алтанзул	1.6	19.0
<b>НИЙТ ДҮН</b>							<b>114.8</b>	<b>12,043.4</b>